

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

20.09. оны 05 сарын 01. өдөр

№ АТ-20/43-240/03

Улаанбаатар хот

Энэхүү хамтран ажиллах гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас Улаанбаатар /14230/, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол, Нарны зам-62, Юнион Бюлдинг, А блок, 7 давхар хаягт байрлалтай Улсын бүртгэлийн 9012001025, регистрийн 5214203 дугаартай “МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК (цаашид “А” тал гэх), нөгөө талаас Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, 25-р хороо, “UB Tower” төвийн 3-р давхар хаягт байрлах улсын бүртгэлийн 9011418048, регистрийн 5726018 дугаартай “ДАБЛЬ ФИШ” ХХК (цаашид “Б” тал, хамтад нь “Талууд” гэнэ) нар нь Монгол Улсын иргэний хууль, Компанийн тухай хууль болон дор дурьдсан нөхцөлөөр харилцан тохиолцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. ЗОРИЛГО

1.1 Талууд нь “Шинэ төмөр зам” төслийн хүрээнд бүтээн байгуулагдах төмөр замын сүлжээнд шаардлагатай мэргэжилтэй ажилтныг бэлтгэх зорилгоор төмөр замын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах, Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх, мэргэжил олгох болон мэргэшүүлэх, зэрэг олгох, давтан сургалт эрхлэх үйл ажиллагааг зохицуулж, талуудын хооронд байгуулсан холбогдох бусад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

Хоёр. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

2.1 Талууд үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж болон энэхүү гэрээг удирдлага болгоно.

2.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ ил тод, шударга, нээлттэй ажиллах зарчмыг баримталж, үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.

2.3 Энэхүү гэрээтэй холбоотой гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ холбогдох гэрээ хэлцлийг талууд тухай бүр байгуулан хамтран ажиллах ба тэдгээр гэрээ хэлцэл нь энэхүү гэрээний бүрэлдэхүүн хэсэг буюу салшгүй хэсэг байна.

2.4 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ нөгөө талын зөвшөөрөлгүйгээр аливаа гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй бөгөөд хэрэв шилжүүлэхээр бол заавал нөгөө талаас бичгээр зөвшөөрөл авсан байна.

Гурав. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3.1 Талууд дараах арга хэмжээг хамтран авч хэрэгжүүлнэ.

Төмөр замын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах чиглэлээр:

3.1.1. Б тал нь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах ажлыг зохион байгуулна.

3.1.2. А тал нь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах ажлыг зохион байгуулахад шаардагдах тусгай зөвшөөрөл авах ажилд дэмжлэг үзүүлнэ.

3.1.3. Шинээр байгуулагдсан Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн нэр “Монголын төмөр зам” МСҮТ гэсэн нэртэй байх бөгөөд талуудын дундын өмч байна.

- 3.1.4. Талууд “Тавантолгой-Зүүнбаян”, Тавантолгой-Гашуунсухайт”, Сайншанд-Бариуун-Урт”, “Баруун-Урт-Хөөт”, “Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замд шаардлагатай мэргэжилтэй ажилтныг богино хугацаанд чанартай сургах, дадлагажуулна.
 - 3.1.5. Талууд тухайн жилд шаардлагатай мэргэжилтэй ажилчдын тоо, мэргэжлийн чиглэл, элсэгчдийн тоог харилцан хэлэлцэж шийдвэрлэнэ.
 - 3.1.6. “А” тал төгсөгчдөөс сонгон шалгаруулалтын үндсэн дээр давуу эрхтэйгээр ажлын байраар хангана.
 - 3.1.7. Талууд МСҮТ-ийн материаллаг баазыг дээшлүүлэх, сургалтын орчин, нөхцөлийг сайжруулах, багшлах боловсон хүчнийг бэлтгэх, үйлдвэрлэлийн орчинд дадлагажуулах, туршлага солилцох зэргээр нягт хамтран ажиллаж, “А” талын туршлагатай инженер, мэргэжилтнүүдийг багшлах нөхцөл боломжоор хангана.
 - 3.1.8. Талууд үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг тухай бүр хэлэлцэж, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар шийдвэрлэнэ.
 - 3.1.9. Талууд орон нутгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй нягт хамтран ажиллах богоод үйл ажиллагааны чиглэл, толовлогоог харилцан хэлэлцэж баталснаар хэрэгжүүлнэ.
- 3.2 Талууд харилцан тохиролцсон тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй.
 - 3.3 Цаашдын хөгжлийн бодлого, ерөнхий чиглэл, томоохон хөрөнгө оруулалт, үл хөдлөх хөрөнгөтэй холбогдсон гэрээ хэлцэл хийх эрхийг Удирдах зөвлөл байгуулах замаар шийдвэрлэнэ.
 - 3.4 Сургуулийг гүйцэтгэх удирдлагаар хангаж ажиллах, багш, ажилтан сонгож ажиллуулах эрхийг Б тал эдэлнэ.
 - 3.5 Талууд сургуулийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор туслах аж ахуй эрхлэх, бусад сургалт дамжааг хичээллүүлэх, бусад байгууллага, иргэдтэй сургалтын үйл ажиллагааг хамтран зохион явуулах, олон нийтэд сурталчлах эрхтэй.

Дөрөв. ТАЛУУДЫН ҮҮРЭГ

- 4.1 Талууд нь энэхүү гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.
- 4.2 Б тал нь А талын эрх бүхий этгээдийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдтэй хамтран ажиллахыг хориглоно.
- 4.3 Үл хөдлөх хөрөнгө, үндсэн хөрөнгө худалдан авах, шилжүүлэх, үйл ажиллагааны чиглэл өөрчлөх зэрэг асуудлыг талууд харилцан тохиролцож байж шийдвэрлэнэ.
- 4.4 Б тал нь А талын зүгээс гаргасан мэргэжлийн чиглэл, суралцагчийн тоо, бусад хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сургалт явуулах үүрэгтэй.
- 4.5 А тал нь Б талд захиалсан мэргэжилтэй ажилтныг захиалсан хэмжээгээр ажлын байраар хангах үүрэгтэй.
- 4.6 А тал нь төмөр замын чиглэлийн мэргэжил олгох, мэргэшүүлэх, давтан сургалтуудыг Б талд хандаж захиална.
- 4.7 Талууд үйлдвэрлэлийн дадлагыг сургалтын төлөвлөгөө, төмөр замын тээврийн онцлог байдлаас хамааруулан тасалдалгүй явуулах үүрэг хүлээнэ.
- 4.8 Талууд хоёр талын эрх ашиг, нэр хүндийг эрхэмлэн ажиллана.

Тав. БУСАД ЗҮЙЛ

- 5.1 Энэхүү гэрээ нь 6 жилийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд талууд гэрээний хугацаанд санал оруулаагүй бол гэрээ анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 5.2 Аль нэг талын буруутай үйл ажиллагаанаас үүсэх хохирлыг үл маргах журмаар шийдвэрлэх бөгөөд хэрэв талууд шийдэлд хүрээгүй бол хуулийн байгууллагаар асуудлыг шийдвэрлүүлнэ. Аль нэг талын буруутай үйл ажиллагаанаас үүдсэн хохирлыг буруутай тал бүрэн хариуцна.
- 5.3 Б тал нь гэрээний 4.2-т заасныг зөрчсөн тохиолдолд А талд 50 сая төгрөгийн торгууль төлнө.
- 5.4 Үйл ажиллагаанаас бий болсон аливаа хөрөнгө болон хөрөнгийн эрхтэй холбоотой асуудлыг талууд нэмэлт гэрээгээр тодорхойлно.
- 5.5 Гэрээний биелэлтийн дүгнэлтийг хичээлийн жилийн дууссанаас хойш нэг сарын дотор багтан талуудын хамтарсан комисс дүгнэнэ.
- 5.6 Энэхүү гэрээг үндэслэн байгуулсан бүхий л холбогдох гэрээ хэлцлүүд хүчин төгөлдөр байна.
- 5.7 Талууд энэхүү гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд харилцан дэмжлэг үзүүлэх ба хоёр талын эрх ашгийг хүндэтгэх зарчмыг баримтална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



“ДАБЛЬ ФИШ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

2020 оны 02 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нэг талаас “Монголын төмөр зам” ТӨХК-д /цаашид МТЗ гэх/, нөгөө талаас “Дабль фиш” ХХК-ийн дэргэдэх төмөр замын мэргэжлийн сургалтын төв /цаашид “Сургууль” гэх хамтад нь “Талууд” гэх/ нар дараах чиглэлээр хамтран ажиллахаар ойлголцолд хүрч энэхүү Хамтын ажиллагааны санамж бичиг /цаашид санамж бичиг гэх/-ийг 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр байгуулав.

Хоёр. Талуудын хамтын ажиллагааны зорилго

2.2. Энэхүү Санамж бичгийн зорилго нь талууд хамтран “МТЗ”-ын дэргэд төмөр замын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулж, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах тус салбарын инженер, техникийн болон мэргэжилтэй ажилтныг үе шаттайгаар бэлтгэх;

2.3. Ажил олгогчийн хэрэгцээ, шаардлагыг хангах замаар талуудын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх;

2.4. Бүс нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжүүдийн түншлэл, хамтын ажиллагааг дэмжих.

Гурав. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ

Хамтын ажиллагааны хүрээнд дараах чиглэлүүдийг хамруулна. Үүнд:

3.1. Оролцогч талууд төмөр замын тээврийн салбарт хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, хамтарсан судалгаа хийх;

3.2. Төмөр замын төсөл хэрэгжиж буй орон нутгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор төрийн захиргааны болон сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах;

3.3. Тухайн бүс, орон нутгийн иргэдэд төмөр замын чиглэлийн мэргэжлийн боловсрол олгох, ажлын байраар хангах;

Дөрөв. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛБЭР

Энэхүү Санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагааг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1. Төмөр замын мэргэжилтэй ажилтан бэлтгэх;

4.2. Талуудын хоорондын үйл ажиллагааг дэмжих;

4.3. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийх;

4.4. Хурал, сургалт, семинар, танилцуулах өдөрлөг зохион байгуулах;

4.5. Түр болон давтан, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах;

4.6. Сургалтын материаллаг баазыг өргөжүүлэх, бэхжүүлэх;

Тав. ХЭРЭГЖҮҮЛЭХ

5.1. Талууд Санамж бичгийн хүрээнд хувийн хэвшлийн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтарсан төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

5.2. Талууд хоорондын найрсаг, шууд харилцаа холбоог бий болгоход чиглэсэн харилцаа, үйл ажиллагааг дэмжинэ.

5.3. Хамтын ажиллагаанд талууд Санамж бичигтэй холбоотойгоор хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр болон бусад үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээллээр харилцан хангаж ажиллана.

Зургаа. БУСАД ЗҮЙЛ

6.1. Талууд бичгээр харилцан тохиролцож энэхүү Санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

6.2. Талууд хамтын ажиллагаагаа бэхжүүлэх үүднээс хамтын ажиллагааны арга хэлбэрийг хэлэлцэх, санамж бичигт дурдаагүй бусад асуудлыг харилцан тохиролцож тухай бүр шийдвэрлэж байна.

Долоо. ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДАЛ

7.1. Энэхүү Санамж бичиг нь Талууд түүнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

7.2. Санамж бичиг нь хүчин төгөлдөр болсноос хойш ... жилийн хугацаанд хүчинтэй байна.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.БАТСҮХ

/гарын үсэг/

“ДАБЛЬ ФИШ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Г.СЭРГЭЛЭН

/гарын үсэг/